



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнххайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн
нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/010/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа

Утас: 99125777

Цахим хаяг: Azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

МӨНХХАЙРХАН СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Б.БАТЗАЯА ТАНАА

2025.03.21 № 2/112

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ховд аймгийн Мөнххайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мөнххайрхан сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 608,224.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 93,244.0 мянган төгрөг буюу 18.2 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН:
ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	525,470.7	547,057.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	352,398.6	332,436.1
33	АВЛАГА	67,862.0	64,057.3
34	УРЬДЧИЛГАА	60,885.0	40,440.0
35	БАРАА МАТЕРИАЛ	35,325.1	70,843.9
36	НӨӨЦИЙН БАРАА	9,000.0	39,280.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,836,607.8	2,918,083.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,836,607.8	2,918,083.7
39200	Биет хөрөнгө	2,748,802.0	2,825,417.3
39300	Биет бус хөрөнгө	87,805.8	92,666.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,362,078.6	3,465,141.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,092.5	19,138.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,092.5	19,138.0
41300	Өглөг	5,092.5	19,138.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,356,986.1	3,446,003.0
51	Засгийн газрын хувь оролцоо	3,356,986.1	3,446,003.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,146,916.9	1,146,916.9
51200	Хуримтлагдсан үр дүн	2,129,886.7	2,218,903.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,182.5	80,182.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,362,078.6	3,465,141.0

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,487,894.3	2,603,415.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	489,405.6	605,099.2
110	Орлогын албан татвар	231,583.1	449,894.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	247,229.8	468,693.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-15,646.6	-18,799.0
113	Хөрөнгийн албан татвар	38,431.1	39,511.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	219,391.4	115,693.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	805,547.1	354,310.0
120	Нийтлэг татварын бус орлого	805,547.1	354,310.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,192,941.6	1,644,006.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,980,664.1	2,485,066.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,980,664.1	2,477,204.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,978,819.1	2,380,738.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	473,326.7	739,473.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,956.4	92,235.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,951.5	488,465.8
2104	Хангамж, бараа материалын зардал	543,460.1	488,216.7
2105	Нормативт зардал	422.5	786.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,656.0	15,515.9

2107	Томилолт, зочны зардал	7,920.0	9,254.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	347,453.5	63,961.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	506,672.4	482,829.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,845.0	96,466.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	7,861.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	507,230.2	118,349.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	6,887.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	507,230.2	111,461.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,012,045.5	2,237,129.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	489,405.6	605,099.2
110	Орлогын албан татвар	231,583.1	449,894.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	247,229.8	468,693.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-15,646.6	-18,799.0
113	Хөрөнгийн албан татвар	38,431.1	39,511.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	219,391.4	115,693.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	44,269.9	23,965.8
1181	Газрын төлбөр	7,367.1	5,236.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	167,754.4	86,491.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,696.5	13,815.1
120	Нийтлэг татварын бус орлого	75,696.5	13,815.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,446,943.4	1,618,215.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,395,214.3	1,580,557.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,395,214.3	1,580,557.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,139,371.0	1,484,091.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	473,326.7	738,891.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,956.4	92,691.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,682.6	488,465.8
2104	Хангамж, бараа материалын зардал	24,382.4	34,071.8
2105	Нормативт зардал	502.4	552.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,547.6	15,008.4
2107	Томилолт, зочны зардал	7,069.5	9,379.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	348,744.0	65,795.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	182,159.4	39,234.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,255,843.3	96,466.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	616,831.2	656,572.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	407,880.6	669,647.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	407,880.6	669,647.1
2200	Дотоод эх үүсвэрээр	407,880.6	669,647.1

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-407,880.6	-669,647.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-16,266.5	-6,887.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	16,266.5	6,887.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	192,684.1	-19,962.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	159,714.5	352,398.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	352,398.6	332,436.1

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,841,552.2	2,841,552.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,868.8	8,868.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,850,420.9	2,850,420.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-665.0	-665.0
9	Тайлант үеийн үр дүн	507,230.2	507,230.2
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,356,986.1	3,356,986.1
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,356,986.1	3,356,986.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-22,445.0	-22,445.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,334,541.1	3,334,541.1
19	Тайлант үеийн үр дүн	111,461.9	111,461.9
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,446,003.0	3,446,003.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,339,602.8	2,122,142.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,653,058.1	1,627,727.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,556,591.6	1,531,260.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	745,504.2	738,891.6
210101	Үндсэн цалин	396,224.7	393,382.9
210102	Нэмэгдэл	287,457.4	284,230.3
210104	Урамшуулал	38,062.1	37,518.5
210105	Гэрээт ажлын хөлс	23,760.0	23,760.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,188.0	92,691.7
210201	Тэтгэврийн даатгал	63,367.9	63,026.3
210202	Тэтгэмжийн даатгал	7,455.1	7,416.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,628.3	5,634.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,826.6	1,781.3

210205	Эрүүл мэндийн даатгал	14,910.1	14,832.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	494,677.2	488,465.8
210301	Гэрэл, цахилгаан	34,184.5	30,714.5
210302	Түлш, халаалт	457,342.7	455,401.3
210303	Цэвэр, бохир ус	3,150.0	2,350.0
2104	Хангамж, бараа материалын зардал	32,376.3	31,153.7
210401	Бичиг хэрэг	4,356.8	4,452.4
210402	Тээвэр, шатахуун	24,103.8	24,099.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,915.7	2,601.6
2105	Нормативт зардал	553.7	552.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553.7	552.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,456.6	15,908.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317.0	317.0
210604	Урсгал засвар	17,139.6	15,591.4
2107	Томилолт, зочны зардал	9,496.5	9,379.6
210702	Дотоод албан томилолт	9,496.5	9,379.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,054.8	64,283.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,040.8	62,136.7
210803	Даатгалын үйлчилгээ	346.0	266.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	285.0	237.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34.0	22.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,291.5	564.1
210807	Газрын төлбөр	1,057.5	1,056.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,284.3	89,934.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	89,666.3	85,997.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,618.0	3,937.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,466.5	96,466.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,466.5	96,466.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,007.6	49,007.6
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,617.4	45,617.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,841.5	1,841.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	524,512.7	487,527.6
220001	Барилга байгууламж	235,934.3	223,345.2
221001	Их засвар	103,000.7	95,463.7
222001	Тоног төхөөрөмж	31,000.0	29,277.5
223001	Бусад хөрөнгө	154,577.7	139,441.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	162,032.0	6,887.5
230001	Эргэж төлөгдөх зээл	162,032.0	6,887.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,339,602.8	2,115,372.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00

310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,971,849.2	2,104,682.7
320001	Орон нутгийн төсвөөс	1,591,798.3	1,724,631.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	380,050.9	380,050.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	367,753.6	10,690.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.0	605.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,750.0	10,085.1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	352,398.6	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	193,085.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	186,315.9
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	58.00	60.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	29.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
620004	Гэрээт ажилтан	3.00	4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.00	29.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00
650010	Гэрээт ажилтан	3.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	160,741.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,752.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,960.9
2104	Хангамж, бараа материалын зардал	3,238.1
210402	Тээвэр, шатахуун	3,238.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,122.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,122.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,600.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,600.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,791.3
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,791.3
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	25,791.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	125,989.0
2200	Дотоод эх үүсвэрээр	125,989.0
220001	Барилга байгууламж	125,989.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	160,741.2

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	160,741.2
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	143,410.9
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,330.3

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 53,127.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 46,345.0 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- Үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авснаар тайлагнаж 46,345.0 мянган төгрөгөөр нэгтгэсэн тайланд зөрүүтэй илэрхийлсэн.

Залруулагдаагүй нийт 6,782.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6,782.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 5,424.0 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж, 1,358.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт бичлээ.

Аудитаар нийт 5,424.0 мянган төгрөгийн 2 заалттай зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: ОНХС-ийн ажлын захиалагчийн хяналтын зардлыг суутган аваагүй 1,358.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6. “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2. “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон.

3.2 Зөвлөмж

3.2.1 Орон нутаг хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2024 оны ОНХС-аар хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний дийлэнх нь батлагдсан зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй ажлын даалгавраар хийгдсэн байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.3.3 "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ОНХС-аар хэрэгжүүлэх ажилд ОНХС-ын үйл ажиллагааны журамд заасан үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөн санхүүжүүлэх, энэ талаар сумын ИТХ-ын хуралдаанд танилцуулах.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2.2 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй дэд хөтөлбөрүүд баталсан. Үүнд: /Аварга хөтөлбөр, Бусад хөтөлбөр арга хэмжээ/ гэх мэт: Уг хөтөлбөрүүдээс Засаг даргын захирамжаар урсгал үйл ажиллагааны шинжтэй замын зардал, шатахуун, малын үнэ, багшийн шагналын мөнгө, тэмцээний шагналын зардал олгосон нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4. "Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй", ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.4. "Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ" гэсэн заалтыг мөрдөөгүй,

Өгсөн зөвлөмж: *Илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх. Хөтөлбөр арга хэмжээ нэрийн дор урсгал үйл ажиллагааг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоож хөтөлбөрийн хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийг тооцон ажиллах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 07 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ТТЗ	Үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авснаар тайлагнасан.	1	46,345.0			1	46,345.0	1	46,345.0				
	ДҮН	1	46,345.0			1	46,345.0	1	46,345.0				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Орон нутгийн хөгжлийн сан	Батлагдсан зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй ажлуудыг санхүүжүүлсэн.	1						1			
Орон нутгийн хөгжлийн сан	Хөтөлбөрүүдээс урсгал үйл ажиллагааны шинжтэй удирдлагыг хэрэгжүүлэх зардал санхүүжүүлсэн.	1	5,424.5					1	5,424.5		
Орон нутгийн хөгжлийн сан	Захиалагчийн хяналт зардал суутган тооцоогүй.	1	1,358.2	1	1,358.2						
		3	6,782.7	1	1,358.2			2	5,424.5		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР : Х.БОЛДБААТАР 2025 оны 03 сарын 21

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН 2025 оны 03 сарын 21

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: Ц.АЗЗАЯА 2025 оны 03 сарын 21

[Type here]

